

МОНГОЛ УЛС ДАХЬ ГАЛТ ЗЭВСГИЙН НАЙМААНЫ ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭВ ШИНЖ, ЧИГ ХАНДЛАГА, ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

CURRENT SITUATIONS OF ILLICIT FIREARM TRAFFICKING, ITS FEATURES, TRENDS, AND COOPERATION OF LAW ENFORCEMENT ORGANIZATIONS ON THIS ISSUE



Ц.ОЧГЭРЭЛ

ЦЕГ-ын ГХТА-ны Хэрэг бүртгэх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа
OCHGEREL TS.

Head of crime recording department, Police Colonel of Agency against
crime of General police department

Товч агуулга: Энэ нийтлэлд Монгол Улс дахь галт зэвсгийн хууль бус наймааны өнөөгийн байдал, үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл, хөндөж буй асуудлаар гүнзгийрүүлэн судалгаа хийх шаардлага, галт зэвсэг эзэмшилтийн талаар хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл зэргийг тусгасан болно.

Abstract: This article is to examine current situation of illegal trafficking of firearms, its cause and circumstances, necessity of doing deeper research on the related issue as well as rationale of upgrading the relevant legal regulations and brining some amendments into the law.

Түлхүүр үгс: Галт зэвсгийн наймааны хууль бус эргэлтийг мөрдөн шалгах, хууль бус эргэлтэнд байгаа мөнгөний хэмжээг тодорхойлох, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Key words: Investigate the circulation of illicit fire arms trafficking, find out the money circulating in this illegal business, expand the cooperation of law enforcement organizations.

Галт зэвсгийн бүртгэл судалгаа, нөхцөл байдлын талаар

Монгол Улсад 2014 оны байдлаар цагдаагийн байгуулага иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа **47256** галт зэвсгийг бүртгэж, үнэмлэх, гэрчилгээ олгосон байна. Үүний дотор зориулалт, зөвшөөрлийн ангилалаар ан агнах **44592**, харуул хамгаалалтын **1522**, спорт сургалтын **634**, музейн үзмэр, урлагийн **301**, цуглуулгын **207** галт зэвсэг бүртгэлтэй байна.¹

2000 онд хийсэн албан бус судалгаагаар Монгол Улсад 11000 орчим галт зэвсэг бүртгэлтэй байсан ба өнгөрсөн 14 жилийн хугацаанд 47.2 мянга гаруй галт зэвсэг бүртгэгдэж, тоон үзүүлэлт нь 4 дахин өссөн, жилд дундажаар 3.3 мянган нэгж галт зэвсгээр нэмэгдсэн байна.

Цагдаагийн байгууллагын мэргэжилтнүүд иргэдийн гар дээр бүртгэлгүй 80.000 орчим галт зэвсэг байж болзошгүй гэсэн тооцоог хийсэн байдаг.²

¹ ЦЕГ-ын Лицензийн төвийн танилцуулга (2014)

² ЭЦГ-ын 4-р хэлтсийн танилцуулга (2014)

Хэдийгээр цагдаагийн байгуулагаас жил бүр галт зэвсгийн тооллого явуулж, бүртгэл судалгааг шинэчлэх ажлыг явуулдаг ч бүртгэлтэй галт зэвсгийн 7.5 -13,1 хувь нь тооллогонд хамрагдалгүй үлддэг, иргэдийн галт зэвсгээ бүртгүүлэх үүргээ биелүүлэхгүй хариуцлагагүй байдал нь бүртгэлтэй галт зэвсгүүдийн шилжилт хөдөлгөөнд бүрэн хяналт тавих ажилд байнгын хүндрэл үүсгэж байна.

Үүний цаана санаатай, санамсаргүй галт зэвсгийн хууль бус наймааны хэлбэр нуугдаж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Улсын хэмжээнд 279 галт зэвсгийг эрэн сурвалжилж байгаагаас 49,8 хувь буюу 139 нь байлдааны зориулалттай, 50,2 хувь буюу 140 нь ан **агнуурын болон бусад зориулалтын галт зэвсэг байна.**³

Галт зэвсгийн наймааны хууль бус эргэлт үүсэх шалтгаан, нөхцөл

Монгол Улсын хилээр галт зэвсэг импортлох зөвшөөрөл бүхий хувь хүн, аж ахуйн нэгжүүд АНУ, ОХУ, Чех, Турк улсад үйлдвэрлэсэн Ремингтон, Вепрь, Тигр, СКС, Сайга, ТОЗ, CZ, Winolargo загварын буунууд, сум хэрэгслийн хамт оруулж байна.

Тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүд нь галт зэвсэг, сумыг зах зээлийн үнээс өндөр үнээр зарж борлуулж байгаа нь худалдан авагчдыг "хууль бус зах зээл"-рүү түлхэж байна.

Өнгөрсөн 2014 онд зөвшөөрөл бүхий "Хорсмен клуб", "Асэ тревэл" ХХК-ууд ан агнуурын зориулалттай 213 буу (галт зэвсэг)-г иргэдэд худалдаалжээ.⁴

Манай улсад ан агнах боломж жилийн турш байдаг нь галт зэвсэг, сумны байнгын эрэлт хэрэгцээг бий болгож буйн зэрэгцээ дээрх эрэлт хэрэгцээг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн оруулж ирдэг галт зэвсэг, сумны импортын тоо хэмжээ бүрэн хангаж чадахгүй байгаа нь галт зэвсэг, сум хэрэгслийн хууль бус наймааны эргэлт үүсэх нөхцлийг бүрдүүлж байна.

Иргэд түгээмэл эзэмшдэг бууны (7,62*39, 7,62*54) ан агнуурын зориулалттай сумыг "Их ав" төв нь импортолж нийтэд худалддаг ч чанарын шаардлага хангахгүй, олдоц ховор, үнэтэй зарж байгаатай холбоотойгоор хууль бусаар галт зэвсэг, сум оруулж ирэх, ченж гэх хүмүүсээр дамжуулан батлан хамгаалах салбарт ашиглаж байгаа байлдааны зориулалттай сумыг олж авч хэрэглэх байдал ажиглагдах болов.

Ан агнуурын зориулалттай карабин загварын галт зэвсгийн сумны дийлэнх нь манай зэвсэгт хүчинд хэрэглэгддэг автомат АКМ, мэргэн буудагчийн винтовийн калибрытай таардаг нь батлан хамгаалах салбар, анги нэгтгэлүүдийн галт хэрэгсэл хариуцсан алба хаагчдаас байлдааны зориулалттай галт зэвсэг болон сум хэрэгслийг хулгайлан гадагш гаргаж хууль бусаар худалдаалан олз ашиг олох үйлдэлд түлхэж, энэ нь зохион байгуулалтанд орж өргөжсөнөөр, иргэдийн гар дээр байлдааны зориулалттай сум хэрэглэл хуримтлагдах нөхцөл үүсэв.

Монгол Улсад нийлүүлэгдэж буй ан агнуурын зориулалттай галт зэвсэг, сум хэрэгсэлийг гол төлөв ОХУ, БНЧУ, АНУ-д үйлдвэрлэсэн байдаг бөгөөд улсын хилээр нууцаар, зөвшөөрөлгүй оруулж ченжүүдээр дамжуулан зарж борлуулах ажлыг зохион байгуулалттай эрхэлдэг бүлэг хүмүүс бий болсон байна. Галт зэвсэг, сум хэрэгслийг хилээр хууль бусаар оруулж ирсэн тохиолдол 2012 онд 5, 2013 онд 3, 2014 онд 3 тус тус бүртгэгдсэн байна.

³ Мөн танилцуулга.

⁴ ЭЦГ-ын 4-р хэлтсийн танилцуулга (2014)

Гэмт хэргийн тоо жил бүр өссөөр байгааг анхааралдаа авч, галт зэвсгийн эх сурвалжид судалгаа, шинжилгээ хийж, галт зэвсгийн хууль бус наймааны эргэлтэй холбож үзэх шаардлага байгаа бөгөөд гэмт этгээдийн арга ажиллагаа улам боловсронгуй болж байгааг хүлээн зөвшөөрөх ёстой хэмээн судлаачийн хувьд үзэж байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээгээр галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 2008 онд 71, 2009 онд 49, 2010 онд 27, 2011 онд 39, 2012 онд 41, 2013 онд 74, 2014 онд 82-т хүрч, олон жилийн дунджаас өссөн үзүүлэлттэй байна.⁵

Галт зэвсгийн наймааны хууль бус эргэлтийн зарим хэв шинж

Иргэд хоорондын галт зэвсгийн хууль бус наймаа дараах хэв шинжийг агуулж байна:

- улсын хилээр хууль бусаар оруулж ирсэн галт зэвсэг, сум хэрэглэл худалдаалах;
- байлдааны зориулалттай галт зэвсгийн зориулалтыг өөрчлөн засварлаж худалдаалах;
- ангын бууг зөвшөөрөлгүйгээр дамжуулан худалдаалах зэрэг болно.

Галт зэвсгийн хууль бус наймааны эргэлтийг нэмэгдүүлж буй өөр нэг хэлбэр, бол спорт буудлагын холбоодын шугамаар оруулж холбооны гишүүдэд хөнгөлттэй нөхцлөөр борлуулдаг галт зэвсэг, сум хэрэглэлийн худалдаа юм. Энэ үйлдэл нь аж ахуйн нэгжийн хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаа мэт харагдавч, галт зэвсэг худалдаалах тухай хууль тогтоомжийн цоорхойг ашигласан галт зэвсгийн хууль бус наймааны хэв шинжийг агуулсан үйлдэл гэж үзэж болохоор байна.

Галт зэвсэг ашиглаж сурах гэсэн иргэн бүр буудлага спортын сургалтанд хамрагдаж гишүүн болох боломжтой, төлбөрөө төлсөн бол сургалтанд хамрагдах эрхтэй байдаг. Эдгээр иргэд цагдаагийн байгууллагаас галт зэвсэг эзэмших эрх олгох шалгуурыг бүрэн дүүрэн хангаж чадах эсэх эсвэл холбоо, төрийн бус байгууллагын нэрийн дор ямар ч хяналтгүйгээр галт зэвсэг эзэмшиж байгаа эсэхэд буудлагын холбоо, түүнчлэн цагдаагийн байгууллага хариулт өгч чадахгүй байна.

Энэ нь спорт буудлага, сургалт хийх зөвшөөрөлтэй төрийн бус байгууллагын галт зэвсгийн хадгалалт хамгаалалтын талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болох шаардлага бий болсныг харуулж байна.

Монгол Улсын иргэд, гадаадын иргэдтэй хамтран эсвэл дангаараа галт зэвсгийн хууль бус наймаа хийх оролдлогууд гарсаар байна. Гадаад улсад олон жил амьдарсан манай зарим иргэд автомашины худалдаа, бусад төрлийн бизнес эрхлэхийн зэрэгцээ, экспортоор бараа бүтээгдэхүүн гаргадаг зөвшөөрлөө ашиглан ачаа тээшинд галт зэвсэг, сум хэрэгсэл нууж оруулах хэд хэдэн оролдлого хийснийг цагдаагийн байгууллага бүртгэж шалгажээ. Мөн дипломат эрх ямба бүхий этгээдүүд бүрэн эрхийнхээ хүрээнд галт зэвсэг, сум хэрэгсэл нууцаар оруулж ирж байгаа талаар мэдээлэл байдаг.

Галт зэвсгийн хууль бус наймааг илрүүлэх, таслан зогсоох ажиллагаа, түүний үр дүн хууль сахиулах байгууллагуудын, түүн дотроо гадаад орны байгууллагуудтай хийж буй хамтын ажиллагаанаас ихээхэн шалтгаалах учиртай юм.

Галт зэвсгийн наймааны хууль бус эргэлтийн талаар

Хэдийгээр Монгол Улс дахь галт зэвсгийн хууль бус наймааны эргэлтийн цар хүрээ нь харьцангуй хязгаарлагдмал, хууль бус наймааны хэв шинжийг агуулж байгаа ангын буу, сум хэрэглэлийн худалдааны тоо хэмжээ харьцангуй бага хэдий ч хууль бус эргэлтийн үнэ өртөг хэдийнээ 100 сая төгрөгөөс давж борлуулагдах зах зээл нэгэнт бий болжээ гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Улаанбаатар хотын болон зарим аймгийн хар зах дээр ченжүүд дээр дурдсан

⁵ ЦЕГ-ын Лицензийн төвийн танилцуулга (2014)

зориулалтыг өөрчилсөн ангын бууг болон тэдгээрт ашиглагдаж байгаа сум хэрэглэлийн наймааг хууль бусаар эрхлэсээр байна.

Нарантуул, Хар хорин зах дээр хууль бусаар галт зэвсэг, сум зарж борлуулдаг 3 ченжид шалгалтын ажиллагааг явуулахад нийт 10 мянга орчим сумыг хууль бусаар хадгалж байсныг тогтоосон бөгөөд уг зах дээр сумны хууль бус наймаа эрхлэж байгаа 23 ченж байдаг гэсэн судалгаанд үндэслэн, тэдэнд байгаа сумны тоо, түүний үнийг ойролцоогоор тооцоолоход 60-70 орчим мянган сум, зах зээлийн үнэлгээ ойролцоогоор 89.0-103.9 сая төгрөг болж, энэ мөнгөөр 1-2 улиралд хууль бус эргэлт явагдаж байна гэсэн албан бус мэдээлэл байдаг. Үүн дээр хууль бусаар наймаалагдаж байгаа галт зэвсгийн үнийг оруулж тооцвол дээрх үнэлгээ хэдэн арван саяаар нэмэгдэх нь ойлгомжтой.

Улсын хэмжээнд галт зэвсэг, сум хэрэгслийн наймааны хууль бус эргэлтэнд байгаа тоо хэмжээ, үнэлгээг шинэчлэн тогтоох судалгааг хийх зайлшгүй шаардлага үүнээс харагдаж байна.

Галт зэвсгийн хууль бус эргэлтийн улс дамжсан хэлбэр хэдийнээ бүрэлдэн бий болсон нь анхаарал татаж байна.

Манай улсын иргэдээс БНХАУ-ын Шинжаан Уйгарын автономит улс руу галт зэвсэг, сум хэрэгсэл хууль бусаар нууж гаргасаныг Хятадын холбогдох байгууллага илрүүлэн шалгасан талаар мэдэгдсэн нь галт зэвсгийн хууль бус наймааны эргэлт хил дамнасан зохион байгуулалтын хэлбэрт шилжсэнийг харуулж байна.

Хил дамнасан галт зэвсгийн хууль бус эргэлт ерээд оны сүүл үеэс эхлэсэн байж болохоор харагддаг бөгөөд хилийн цэргийн анги, зэвсэгт хүчний ангийн агуулахаас их хэмжээний галт хэрэгсэл хулгайлсан гэмт хэргүүд үүнийг гэрчилдэг. Тухайлбал, 2003 онд Баян-Өлгий аймаг дахь хилийн цэргийн дугаар ангиас 30 нэгж, төрлийн (гар буунаас тасгийн пулемет хүртэл) байлдааны галт зэвсэг алдагдсан байдаг бөгөөд БНХАУ-ын Шинжаан Уйгарын автономит улс руу гарсан галт зэвсэг тэдгээр алдагдсан байлдааны буунууд байж болох магадлалтай. БНХАУ-ын холбогдох байгууллагатай хамтран ажиллаж дээрх мэдээллийг шалгаж, гэмт үйлдлийг илрүүлэн нотлох шаардлагатай.

Өнөөдөр улсын хэмжээнд 279 галт зэвсгийг эрэн сурвалжилж байгаагаас 49,8 хувь буюу 139 нь байлдааны зориулалттай, эдгээр галт зэвсгээс 66 гар буу, 4 (СВД) мэргэн буудагчийн винтов, 3 (РПКН) тасгийн пулемет, 32 автомат АКМ, 34 ширхэг пулеметны гол төмөр гэсэн судалгаа байдаг.

Ангын болон бусад зориулалтын 140 галт зэвсгээс, 5,6 мм-ийн калибрытай ТОЗ-8 загварын галт зэвсэг 60, нэг болон хос амтай дробовик 29, СКС винтов 11, карабин 40 болон бусад загварын бууг эрэн сурвалжилж байна.⁶

Цаашдын чиг хандлага

Галт зэвсэг, сум хэрэгслийн наймааны хууль бус эргэлтийн тодорхой хэлбэрүүд бий болж, тэдгээрийг үйлдэх арга, ажиллагаа нь улам боловсронгуй болсоор байна. Энэ төрлийн наймааг дагнан үйлдэж, зохион байгуулалттай сүлжээ хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа бүлэг этгээдүүд тусгай зөвшөөрөл нэрийн доор их ашиг орлогын төлөө хууль бус наймаагаа үргэлжүүлэн явуулсаар байгааг дээр дурдсан.

Зэвсгийн хууль бус наймааны өөрийн гэсэн мөнгөний эргэлт нэгэнт бий болж, хэрэглэгчийн сүлжээ хүрээлэлтэй болсон байна. Эрх зүйн зохицуулалт оновчтой бус байгаагаас хуулийн цоорхой үүсэж ийм төрлийн үйлдлийг үргэлжлүүлэн хийх нөхцлийг үүсгэж байна.

Цагдаагийн байгууллагаас галт зэвсгийн наймааны хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр явуулж байгаа олон төрлийн ажил байгаа боловч дан ганц цагдаагийн

⁶ ЭЦГ-ын 4-р хэлтсийн танилцуулга (2014)

байгууллагын хүч хэрэгслээр уг асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.

Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа

Монгол Улсын хувьд “галт зэвсгийн наймааны хууль бус эргэлт” хэмээх ойлголт, ухагдахуун хангалттай судлагдаагүй, зарим судалгаа, шинжилгээ цэргийн мэргэжилтнүүдийн хүрээнд хийгдэх төдийгөөр хязгаарлагддаг, галт зэвсгийн хууль бус эргэлттэй зөвхөн цагдаагийн байгууллага тэмцдэг байдал өнөөг хүртэл үргэлжилсээр байна.

Галт зэвсэг хэрэглэн үйлдэж байгаа гэмт хэргийн тоо жилээс жилд өсөж байгаа энэ цаг үед галт зэвсгийн хууль бус наймааны эргэлттэй тэмцэх чиглэлээр төрийн тусгай албадын харилцан ажиллагаа хангалттай биш гэж дүгнэж болох бөгөөд цаашид илүү өргөн хүрээтэй хамтын ажиллагаанд тулгуурлах шаардлага байгаа нь харагдаж байна.

Галт зэвсгийн хууль бус наймааны эргэлтэд тавих хяналтыг сайжруулах асуудлыг анхааралын гадна орхивол өнөөдөрийн хар тамхи мансуурах бодисын эргэлт асуудал, хяналтаас алдагдсантай адилхан болохыг үгүйсгэх аргагүй юм.

Дүгнэлт:

1. “Зэвсгийн (галт зэвсгийн) наймааны (худалдаа)-ны хууль бус эргэлт” хэмээх ойлголтыг нарийвчлан судлах, онолын асуудлуудыг нээн гаргах;

2. Монгол Улс дахь галт зэвсгийн наймааны хууль бус эргэлтийн мөнгөний хэмжээг ойролцоогоор тогтоох судалгааны ажлыг хийх, дээрх үйл ажиллагаа эрхлэгчдийн (бүлэглэлийн) тоог гаргах;

3. Эрэн сурвалжлагдаж байгаа галт зэвсгийн ангилал, төрлийг нарийвчлан гаргах, хулгайлагдсан, алдагдсан болон тооллогоор дутагдсан гэсэн хэрэг бүрт дүн шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгөх;

4. Гадаадын болон дотоодын хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдааг сайжруулж, тэдгээрийн гүйцэтгэх ажил эрхлэж байгаа нэгжүүд тодорхой шалгах асуудлаар тодорхой үе шаттай төлөвлөгөө боловсруулж, нягт хамтран ажиллах;

5. Цагдаагийн байгууллага энэ төрлийн асуудлыг хариуцдаг нэгж, ажилтнуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хөрш зэргэлцээ орнуудын холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж уялдаа холбоог сайжруулах.